

”ИРГЭДДЭЭ МЭДЭЭЛЭЛ ХЭРХЭН Т ҮГЭЭХ ВЭ?”

Орон нутгийн удирдах ажилтанд зориулсан хөтөч

Мэдээллийн эрх чөлөө гэж юу вэ?

Мэдээллийн эрх чөлөө гэдэг нь иргэд төрийн байгууллагаас аливаа мэдээллийг чөлөөтэй авахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн мөнгөөр ажиллаж буй төр өөрийн үйл ажиллагааны талаарх аливаа мэдээллийг иргэдэд нээлттэй, чөлөөтэй түгээх болон иргэд өөрт хэрэгтэй мэдээллийг хэрэгтэй цагтаа, төрийн байгууллага, албан тушаалтнаас саадгүй авч байхыг хэлнэ. Төр мэдээллийг татварын мөнгөөр хуримтлуулдаг тул энэ нь төрийн байгууллага, албан тушаалтны бус, харин ард түмний өмч юм. Мэдээллийн эрх чөлөөг иргэдийн мэдэх эрх ч гэж нэрлэдэг.

Мэдээллийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн суурь зарчмын нэг юм. Өөрөөр хэлбэл төр нь иргэддээ үйл ажиллагааныхаа талаар мэдээлдэг, тайлагнадаг, тэдний шийдвэр гаргахад оролцох эрхийг нь хүндэтгэдэг байх зарчим дээр тулгуурладаг. Түүнчлэн, сайн засаглал болон төрийн ил тод, хариуцлагатай байдлын гол үндэс, баталгаа болдог. Учир нь иргэд мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлснээр төрийн байгууллагууд улам ил тод, хариуцлагатай болж улмаар сайн засаглал, шударга ёс төлөвших суурь болдог байна.

Мэдээллийн эрх чөлөө нь иргэдийн оролцоог хангах чухал үндэс юм. Иргэд ардчилсан үйл явцад зөвхөн төрийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй үед л оролцох бололцоотой байдаг.

Монгол Улсад мэдээллийн эрх чөлөөг хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй хольж ойлгох нь элбэг байдаг. Энэ нь хоёр тусдаа асуудал ба мэдээллийн эрх чөлөө нь зөвхөн сэтгүүлчдийн бус нийт иргэдийн төрийн

байгууллагаас мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулдаг бол хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь хэвлэлийн бие даасан байдлыг зохицуулдаг.

Мэдээллийн эрх чөлөөний ач холбогдол

Мэдээллийн эрх чөлөө нь иргэний эрхийг хангах, иргэдийг хүчирхэгжүүлэн, нийгмийн идэвхтэй оролцогч болгодог чухал ач холбогдолтой. Түүнээс гадна нийгэмд ялангуяа төрд олон чухал үүрэгтэй байдаг. Үүнээс дурдвал

- **Төрд итгэх итгэл бий болгох**

Нээлттэй засаглал, шийдвэр гаргалтын явц дахь ил тод байдал нь иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлдэг ба энэ нь төрд өөрт нь ашигтай байдаг. Аливаа шийдвэр гаргасан шалтгаан нөхцөл байдлыг олон нийтэд таниулах нь нийгмийн зүгээс дэмжлэг хүлээх, үл ойлголцох байдал болон бухимдлыг бууруулах давуу талтай.

- **Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах**

Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх тусмаа иргэдээс санал, шүүмжлэл ихээр ирж, түүнийг нь зохистой ашиглаж бодитой хэрэгжих шийдвэр гарах үндэслэл болдог байна. Олон нийтэд гаргасан шийдвэрийнхээ тухай мэдээлэл зайлшгүй хүргэх ёстой болдог учраас төр тухайн шийдвэрээ аль болох бодит байдал дээр тулгуурлан, үнэн зөвөөр гаргахад хүрдэг.

- **Авлигаас урьдчилан сэргийлэх хэрэгсэл**

Аливаа мэдээллийг ил тод байснаар төрийн байгууллага дахь хүнд суртал багасч, хууль бус үйлдлийг далдлан нуух боломжгүй болон улмаар авилгаас урьдчилан сэргийлэх боломжтой.

Мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин

Хүн бүрт байх ёстой энэ чухал эрхийг төрөөс баталгаажуулан хангах ёстой. Ингэхдээ уг эрхийг баталгаажуулан, хэрэгжүүлэх тусдаа хууль, эсвэл бусад хууль тогтоомж, бодлогын бичиг баримт батлан гаргадаг.

Олон улсын хэмжээнд анхны Мэдээллийн Эрх Чөлөөний хуулийг 1766 онд Финлянд, Швед улс баталснаас хойш одоогийн байдлаар 70 гаруй улс орнууд Мэдээллийн эрх чөлөөний хуулийг баталсан байна. Ялангуяа шилжилтийн үеийн ихэнх орнууд 2000 оноос эхлэн уг хуулийг батлан хэрэгжүүлж байна.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Олон Улсын Иргэний болон Улс төрийн Гэрээний 19 дүгээр зүйл дээр хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хүлээн авах болон хайх эрхтэй хэмээн заасан нь мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулсан явдал юм.

Монгол Улсын нэгдэн орсон Авлигын Эсрэг НҮБ-ын Конвенци 2003 онд батлагдсан. Энэхүү Конвенцийн 13 дугаар зүйлд нээлттэй байдлыг улам ил тод болгох мөн шийдвэр гаргах явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд мэдээлэл авах боломжийг сайжруулахаар заасан. Монгол улс нэгдэн орсон тул үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх ёстой билээ.

Монгол Улсын хувьд Үндсэн Хуулиараа мэдээлэл авах эрх чөлөөг баталгаажуулсан. Үндсэн Хуулийн арван зургаадугаар зүйлийн 17-д Монгол Улсын иргэн нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй гэж заасан.

Монголд улсад үйлчилж буй 400 гаруй хууль тогтоомжоос мэдээлэл, ил тод, нээлттэй байх зарчим, хэм хэмжээг зохицуулсан 120 гаруй хууль

байдгийн нэг нь төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдал, мэдээллийн эрх чөлөөг хангах чиглэлээр нэлээд шинэлэг зохицуулалт хийсэн Авлигын эсрэг хууль юм.

Төрийн алба, үйл ажиллагааны гол зарчмыг тодорхойлсон Төрийн Албаны тухай хуулийн 4.2.2, 4.2.3-д **төрийн албаны баримтлах ёстой зарчмын нэг нь ил тод байх, ард түмэнд үйлчлэх** гэж заажээ.

Мэдээлэл олж авах, хүртэх эрхийн хууль зүйн баталгааг бүрдүүлэх зорилгоор Мэдээллийн эрх чөлөөний хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэх шатандаа явж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оньүйл ажиллагааны хөтөлбөрийн 4 хэсэгт эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох зорилт дэвшүүлэн үүний хүрээнд “4.5.4.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан, иргэнд үйлчлэх үндсэн чиг үүрэг бүхий, авлига, хүнд суртлаас ангид, чадварлаг, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож хариуцлагыг дээшлүүлнэ.” гэж заажээ.

Мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах үндэслэл байдаг уу?

Зарим мэдээлэл нь улс орны ашиг сонирхол, аюулгүй байдал, хувь хүний нууцыг хамгаалах үүднээс нууцлагдсан байж болдог. Гэхдээ ийнхүү нууцлах үндэслэл, ангиллыг зөвхөн хуулиар зохицуулсан байдаг. Аливаа хуулинд заасан үндэслэлээс гадуур эсвэл гажуудуулан мэдээллийг иргэдэд өгөхөөс татгалзах ёсгүй юм.

Монгол улсад нууцлалын асуудлыг Төрийн Нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулсан. Төрийн нууцын жагсаалтыг УИХ-аас баталдаг тул бусад байгууллага үүнээс бусад мэдээллийг нууцлахыг хориглодог. Байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл,

давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болдог. Гэхдээ тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл; хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл; гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг нууцлахыг хориглосон.

Орон нутагт мэдээллийн эрх чөлөөг хэрхэн хангах вэ?

Дээр дурдсан хууль тогтоомжинд заасан зарчим, үүрэг хариуцлагыг орон нутагт хэрэгжилтийг хангах гол субъект нь орон нутгийн удирдлага юм. ИТХ нь төлөөллийн байгууллага тул орон нутгийн иргэдийн эрх ашгийг төлөөлөн бодлого боловсруулах, хэрэгжилтийг хянах үндсэн институт юм. Иймээс ИТХ өөрийн нутаг дэвсгэртээ иргэдийн мэдээллийн эрх чөлөөг хангах талаар олон арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой.

Орон нутгийн удирдлагаас ил тод, нээлттэй байдлыг хангах талаар цогц арга хэмжээг доорх арга замуудаар хэрэгжүүлж болно.

- Орон нутагтаа мэдээлэл хүссэн иргэдэд шуурхай түргэн үйлчлэх, хүсэлтийн хариуг удаахгүй хариулах, дээд албан тушаалтнаас заавал зөвшөөрөл авахыг шаардах гэх мэт хүнд суртлыг арилгах. Иргэдээс мэдээллийн үйлчилгээнд өндөр төлбөр шаардахгүй байх
- Мэдээллийг түгээх талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах
- Мэдээлэл түгээх болон иргэд мэдээлэл хүсэхээр хандах бүтцийг бий болгох. Үүнд заавал томоохон бүтцийн өөрчлөлт хийх бус, харин

энэхүү чиг үүргийг тодорхой болгон, хариуцах ажилтны ажил, үүргийн хуваарьт оруулах талаар дотоод зохион байгуулалт хийх асуудал юм.

Орон нутгийн удирдлага иргэддээ ямар мэдээлэл түгээх вэ?

Иргэдэд тухайн орон нутгийн бүхий л мэдээлэл чухал хэрэгцээтэй байдаг. Иргэд хүссэн мэдээллээ шаардлагатай үедээ орон нутгийн зохих байгууллагуудаас авах боломжтой байхаас гадна зарим мэдээллийг орон нутгийн удирдлагаас иргэддээ идэвхтэйгээр түгээн хүргэх нь нэн чухал юм.

Үүнд:

- ИТХ, ЗДТГ-ын үйл ажиллагааны тайлан, мэдээлэл
- Орон нутгийн төсөв, түүний зарцуулалт
- Гадаадын зээл, тусламжийн хуваарилалт
- Аудит болон хяналт шалгалтын тайлан
- Төлөвлөгдөж буй болон гүйцэтгэсэн орон нутгийн бараа үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл
- Тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, ялангуяа ашигт малтмалын компанийн талаар
- Тэдгээрийн байгаль орчны нөлөөллийн талаар мэдээлэл гэх мэт

Эдгээр мэдээллийг заавал иргэд өөрсдөө хүсэхийг хүлээлгүй түгээн мэдээлэх нь зүйтэй. Энэ нь орон нутгийн засаглал, ил тод байдлын нэгэн чухал үзүүлэлт болно.

Орон нутагт ямар санаачилга гаргаж болох вэ?

Орон нутгийн мэдээлэл олж авдаг сувгууд нь телевиз, мэдээллийн самбар, хурал, яриа таниулг а тул эдгээр сувгуудыг өргөнөөр ашиглах нь зүйтэй. Орон нутгийн удирдлагын зүгээс иргэддээ мэдээлэл түгээх талаар дараах тодорхой санаачилгыг хэрэгжүүлж болно. Үүнд:

- Орон нутгийн удирдлагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээлэл , тухайлбал, дүрэм, журам, ямар үйлчилгээг ямар хугацаанд

- үзүүлэх, бүрдүүлэх шаардлагатай материал зэргийг агуулсан танилцуулгыг боловсруулан мэдээллийн самбартаа байрлуулах
- Эдгээр мэдээллийг хэвлэмэл материал, тодорхой зөвлөгөө бүхий гарын авлага, зурагт хуудас гарган иргэддээ түгээх. Түүнчлэн, орон нутгийнхаа вэбсайтыг ашиглах.
 - Иргэдийг хүлээн авч уулздаг цагийн хуваарьтай байж тогтмол мөрдөх Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэн хариуг өгөх.
 - Иргэд хүссэн мэдээллээ авч чадахгүй байгаа талаар гомдол, санал ирүүлсэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох механизмыг бий болгох
 - Үйл ажиллагааны нээлттэй байдлыг алдагдуулсан дүрэм, журмаа нягтлан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах
 - Ил тод байдлыг хэрхэн хангасан талаар жил бүрийн тайландаа тусгах
 - ИТХ-ын хуралд иргэдийг оролцуулах. Үүнд ИТХ-ын дэгд энэ талаар зохицуулалт хийн зохион байгуулах.
 - Орон нутгийн удирдлагаас төсөв, нийгэм, эдийн засгийн томоохон хөтөлбөр, тулгамдсан нийтлэг асуудал зэргэй холбоотой баримт бичгийн төслийг иргэдэд сурталчилж тэдний саналыг өргөнөөр авах зорилгоор хурал цуглаан зохион байгуулах, хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтээр хэлэлцүүлэх гэх мэт.

“Глоб Интернэшнл” ТББ

Улаанбаатар хот
2009 он